Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ГОВЬСҮМБЭР ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ ШАРХҮҮГИЙН ОТГОНЖАРГАЛЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **НЭГ. БОДЛОГИЙН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН БОЛОН ХУУЛИАР ОЛГОГДСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** *(Алсын хараа 2050 2.1.9, 2.1.10, 2.1.11, 3.1.15 3.1.17, 4.1.19, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2.3.9, 2.5.10 2.3.12, Таван жилийн үндсэн чиглэл 1.3, 2.1 болон бусад хуулиар олгосон чиг үүрэг)* | | | | | | |
| Зорилт 1. Сургуулийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгож, орчин үеийн менежментийн хандлагыг нэвтрүүлэх; | | | | | | |
| 1.1.1 | Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуула. | Хурлын тоо: 4 удаа<br><br>Шийдвэрлэсэн асуудлын биелэлтийн хувь: 100<br><br>Удирдах зөвлөл 1-ээс доошгүй удаа хуралдуулах. | 2023-2024 оны хичээлийн жилийн элсэлтийн саналыг танилцуулан ирэх хичээлийн жилд 345 оюутан, суралцагч элсүүлэх саналыг батлуулсан. | Удирдах зөвлөл 2 удаа хуралдаж, шинэчлэгдсэн дүрмийн дагуу бүтэц орон тоо, сургуулийн дүрэм, 2024-2025 оны элсэлтийн квотыг тогтоон БШУЯ-нд хүргүүлсэн байна. | 2024 оны 04 сарын 30-ны өдөр Удирдах зөвлөл хуралдаж, хурлаар 16 мэргэжлээр 500 суралцагч элсүүлэх элсэлтийн саналыг хэлэлцүүлэн батлуулсан.<br>***Үүнд:***<br>Техникийн боловсролын сургалт:<br>1.5 жилийн ангид 65 оюутан<br>3 жилийн ангид 110 оюутан<br>Мэргэжлийн боловсролын сургалт<br>1 жилийн ангид 160 суралцагч<br>3 жилийн ангид 165 суралцагч<br>-2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулж сургалтын байгууллагын бүтэц орон тоо, 2024-2028 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг батлуулахаар төлөвлөж материал | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүргүүлэн хуралдахад бэлэн болсон байна. | |
| 1.1.2 | Олон улсын ISO:9001:2015, ISO:21001:2018 “Чанарын менежментийн тогтолцоо” стандартыг хэрэгжүүлэх | Сургалтын тоо: 13 удаа<br>Шийдвэрлэсэн асуудал: Олон улсын ISO:9001:2015, ISO:21001:2018 “Чанарын менежментийн тогтолцоо” стандартыг хэрэгжүүлж, хэвшил болгож ажиллах.<br><br>Шийдвэрлэсэн асуудлын биелэлтийн хувь: 100 | ISO:9001:2015, ISO:21001:2018 стандартыг нэвтрүүлэх ажлыг 2023 оны 12 дугаар сарын 01-ээс 2024 оны 04 дүгээр сарын 01-ний хооронд зохион байгуулахаар “Ворлд стандарт консалтинг” ХХК-тай гэрээ байгуулсан. | Эхний хагас жилд: Олон улсын ISO:9001:2015, ISO:21001:2018 “Чанарын менежментийн тогтолцоо” стандартыг хэрэгжүүлтийг хангаж, эхний магадлан аудитаар орж баталгаажсан байна. | ISO 9001:2015, ISO 21001:2018 Нэгдсэн менежментийн тогтолцоо нэвтрүүлэх сургалтын хүрээнд Стандартын 4,5,6,7 дугаар бүлгийн сургалтуудыг нийт 9 өдөр зохион байгуулж, 15 анги, кабинет, 12 өрөө тасалгаа 10 дадлагын газар болон сургуулийн гал тогооны үл тохирлыг илрүүлж, үл тохирлыг арилган ажилласан. 2024 оны 11 дүгээр сарын 10-наас 14-ний өдрүүдэд 4.1-9.1 хүртлэх стандартын шаардлагын дагуух баримтжуулсан мэдээлэлээ гаргасан. Стандарт нэвтрүүлэх сургалтууд бүрэн хийгдэж дууссан 12 дугаар сарын 20-ны дотор хөндлөнгийн Аудитар баталгаажуулалт хийхээр хүсэлт хүргүүлэн төлөвлөн ажиллаж байна. | 100 |
| **Зорилт 1.2. Иргэний мэргэжил, ур чадвар эзэмших хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн чанартай боловсрол сургалтын үйлчилгээ үзүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;** | | | | | | |
| 1.2.1 | Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | Үйл ажиллагааны тоо: 2<br><br>Үйл ажиллагааны биелэлтийн хувь: 100<br><br>Мэргэжлийн зөвлөлийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллах, уялдаа холбоог сайжруулан эрчимжүүлэх. | Үйлдвэрлэлийн техникч мэргэжлийн зөвлөлийн зөвлөх Штефан Франк 5 мэргэжлийн 10 багш, 82 оюутан, суралцагчдад 5 өдрийн сургалтыг 3 чиглэлээр зохион байгуулсан. | **Эхний хагас жилд:** Мэргэжлийн зөвлөлийн хамтран ажиллах гэрээ байгуулан тушаалын хэрэгжилтийг хангаан төлөвлөгөө гаргаж ажиллана.<br>**Жилийн эцэст:** Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдаж тайлагнасан байна. | “МАК” ХХК, “Шивээ-Овоо” ХК, “ОСО” констракшн, “Баян Нексус” ХХК-д Металл хийц болон уул уурхайн ашиглалтын мэргэжлийн зөвлөлд ажиллах мэргэжилтэнг томилуулах хүсэлтийг 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдөр илгээсэн.<br>Мэргэжлийн зөвлөлийн анхдугаар хуралдааныг 2024 оны 12 сарын 5-нд зохион байгуулахаар байгууллагдаж дээрх 2 мэргэжлээр тус бүр 9 хүний бүрэлдэхүүнтэй шинээр | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэргэжлийн зөвлөөлийг байгууллаа. | |
| 1.2.2 | Олон улсын эко сургууль хөтөлбөрт хамрагдах | Хөтөлбөрийн тоо: 1<br><br>Зохион байгуулсан хөтөлбөрийн биелэлтийн хувь: 100<br><br>Хөтөлбөрийн чадамжийн нэгж бүрд хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээ, экологи байгаль хамгааллын тухай ойлголтыг тусгаж сургалтад нэвтрүүлнэ. | Эко сургууль хөтөлбөрийн хүрээнд Мөнгөн гэрэгэ авсан. | Олон улсын эко сургууль хөтөлбөрийн хүрээнд “Ногоон туг” авч сургалтын орчин сайжирч, эрүүл аюулгүй орчин суралцах нөхцөл бүрдсэн байна. | 2024 оны 03 дугаар сарын 21-нээс 3 дугаар сарын 22-нд УБ хотод зохион байгуулагдсан олон улсын Эко сургууль, цэцэрлэгийн Үндэсний VIII чуулганд оролцож, “Мөнгөн гэрэгэ” өргөмжлөл авсан. 2024 оны 11 сарын 09-нд "Байгаль орчны мэдээлэл сургалтын төв" ТББ -руу "Ногоон туг" өргөмжлөлд нэр дэвших шалгаруулалтын үндсэн материалуудыг хүргүүлсэн. Болзол хангасан байгууллагуудыг 2025 оны 2 дугаар сард шалгаруулан “Алтан гэрэгэ”, “Ногоон туг” гардуулах үйл ажиллагаа болно. | 100 |
| 1.2.3 | Хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх, төгсөгчийн мэдлэг, ур чадварыг үнэлэх | Үнэлэх тооцох ажлын тоо: 7<br><br>Үнэлгээний арга зүйн биелэлтийн хувь: 100<br><br>Дотоодын чанарын баталгаажуулалт хийх. | Тайлан хамгаалалт, төгсөлтийн шалгалтад ажил олгогчдын төлөөллийг оролцуулсан. | Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд нийцүүлэн ажлын даалгаврын сан, тестийн санг шинэчилсэн байна. | Боловсролын ерөнхий газрын дарга, Боловсролын үнэлгээний төвийн даргын хамтран баталсан “Анги дэвших, улсын шалгалт зохион байгуулах удирдамжийн дагуу ЕЭ-ийн багш нартай хамтран **7 хичээлийн** блюпринтийг боловсруулан баталуулж 06 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд Говьсүмбэр аймгийн БГ-тай хамтран зохион байгуулсан.<br><br>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/128 тушаалыг үндэслэн **6 мэргэжлийн** хичээлээр 05 сарын 31-06 дугаар сарын 07-ны өдрүүдэд БҮТ-тэй хамтран зохион байгуулсан.<br><br>ТБ-ын 2, 3 дугаар курсийн 85 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | суралцагч, МБ-ын 2,5 жилийн 186 суралцагч үйлдвэрлэлийн болон танилцах дадлагын тайлан хамгаалалтанд хамрагдсан. БҮТ-рүү 2024 оны 12 сарын өвлийн төгсөлтийн хуваарийн саналаа хүргүүлсэн. | |
| 1.2.4 | Сургалтын шаталсан тогтолцоог бий болгох, сургууль хоорондын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн тоо: 2<br><br>Хөтөлбөрийн биелэлтийн хувь: 100<br><br>Нас харгалзахгүй сурах, дараагийн шатны сургуульд суралцах боломжийг хангах. | МБС-ын 2.5 жилийн ангийг Барилгын цахилгаанчин, Автомашины засварчин мэргэжлээр төгссөн 58 төгсөгчийн 22 буюу 38 хувь нь техникийн боловсрол эзэмшүүлэх 1.5 жилийн Уул уурхайн машин механизмын электрон төхөөрөмжийн техникч, Автомашины механик мэргэжлийн ангиудад шатлан суралцаж байна. | Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр шаталсан сургалтад төгсөгчдийн 18 хувийг хамруулсан байна. | 2023-2024 оны хичээлийн жилд “Автомашины засварчин” мэргэжлийн **10 төгсөгч**, “Гагнуурчин” мэргэжлийн **11 төгсөгч**, ТБС-ын 1.5 жилийн Үйлдвэрлэлийн техникчийн ангид, 2024-2025 оны хичээлийн жилд Автомашины засварчин мэргэжлийн **12 төгсөгч**, Механикжсан тээврийн хэрэгсэл, механизмын засвар үйлчилгээ 1,5 жилийн ангиудад нийт **33 суралцагч** тус тус шатлан суралцаж байна. | 100 |
| **Зорилт 1.3. Элсэлтийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн зохион байгуулан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа хийх;** | | | | | | |
| 1.3.1 | ХЗЗ-н эрэлт хэрэгцээ, аж үйлдвэрлэлийн хувьсгал, ногоон буюу эко технологийн хөгжлийн хэтийн төлвийг судлан | Сургалтын тоо: 2<br><br>Элсэгчийн тоо: 30<br><br>Сургалтын биелэлтийн хувь: 100 | Мак цемент ХК-ны захиалгаар “Метал боловсруулах машины оператор /Токарь, фрезер/”, “Зам барилгын машин механизмын оператор” | Ажил олгогч нарын захиалгаар сургалт явуулан орон нутаг дахь МБСБ-ын төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 20 хувиар өссөн байна. | 2024-2025 оны хичээлийн жилд Цагдаагийн хэлтэсээс Уул уурхайн ашиглалтын ангид 15 суралцагч, МАК-ЦЕМЕНТ ХХК-иас Зам гүүрийн байгууламж ангид 15 суралцагч, Хорих 425 ангийн ажилчид болон хүмүүжигч нараас Цахилгаан хангамж, тоног | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ажил олгогчийн захиалгаар сургалт явуулах | | мэргэжлээр 30 ажилтан, “Баатар ван Транс” ХК-ны захиалгаар 30 ажилтан Хүнд машин механизмын оператор, Хүнд машин механизмын засварчин мэргэжлээр МБС-ын 1 жилийн ангийг суралцан төгсөж, төгсөгчдийн 58% нь ажлын байраар хангагдсан. | | төхөөрөмжийн ашиглалт ангид 30 суралцагч, Уул уурхайн машин механизмын угсралт, засвар үйлчилгээны ангид 15 хүмүүжигч, Барилга байгууламжийн угсралт 15 хүмүүжигч, Аймгийн Онцгой байдлын газараас Механикжсан тээврийн хэрэгсэл, механизмийн засвар үйлчилгээны ангид 15 суралцагч, Төрийн байгууллагуудын захиалгаар Бүртгэл тооцоо, хөтлөлтийн ангид 12 суралцагч, нийт 117 суралцагч ажил олгочийн захиалгаар элссэн суралцаж байна. | |
| 1.3.2 | ХЗЗ-н судалгаанд үндэслэн элсэлтийн квотыг тогтоох | Хэрэгжүүлэх ажлын тоо: 1<br><br>Зохион байгуулсан үйл ажиллагааны биелэлтийн хувь: 100<br><br>ОНСЗ-ийн хурлаар хяналтын тоог батлуулах | 2023-2024 оны хичээлийн жилд МБС-ын 1 жилийн ангид 6 мэргэжлээр 105 суралцагч, 2.5 жилийн ангид 6 мэргэжлээр 105 суралцагч, ТБС-ын 1.5 жилийн ангид 3 мэргэжлээр 45 оюутан, 3 жилийн ангид 6 мэргэжлээр 90 оюутан элсүүлэх элсэлтийн санал нь Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/280 дугаар тушаалаар 360 оюутан, суралцагч элсүүлэхээр батлагдсан. 2023- | 2024-2025 оны хичээлийн жилийн элсэлтийн саналыг БШУЯ-ны сайдаар батлуулсан байна. | БШУ-ны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн А/12 дугаар тушаалаар баталсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн хяналтын тоог тогтоох аргачлал”-ын дагуу 2023-2024 оны хичээлийн жилийн статистик тоон мэдээлэл дээр үндэслэн өөрийн үнэлгээг тоон аргачлалын 12 шалгуурын 12 онооноос 8,7 оноо, чанарын аргачлалын 3 шалгуурын 13 онооноос 13 оноо, нийт 21,7 оноогоор хангалттай үнэлгээ авч, 2024-2025 оны хичээлийн жилийн элсэлтийн саналыг 16 мэргэжлээр 500 суралцагч элсүүлэх саналыг боловсруулан сургуулийн удирдах зөвлөлөөр батлуулан БЕГ-т хүргүүлж, батлуулсан. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2024 оны хичээлийн жилд шинээр элсэн орсон 261 суралцагчийн мэдээллиййг сургалт удирдлагын нэгдсэн TVET.EDU.MN системд суралцагчдын мэдээллийг оруулан сар бүр тэтгэлэгийн ирцийг шивж баталгаажуулж байна. | | | |
| 1.3.3 | Төгсөгчдийн ур чадварыг үнэлэх, төгсөлтийн шалгалт авах, үнэлгээ хийх ажилд ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлэх | Шалгалтын тоо: 3<br><br>ААНБ-ын ИТА хамрагдалтын тоо: 15<br><br>Шалгалтын биелэлтийн хувь: 100<br><br>Үнэлгээний шалгуур шаардлагыг хангаж ажиллах. | МБС-ын 2.5 жилийн төгсөх ангийн төгсөлтийн үнэлгээнд 5 ААНБ, ТБС-ын 2 мэргэжлийн диплом хамгаалалтад 2 ААНБ, МБС-ын 1 жилийн төгсөлтийн үнэлгээнд 8 ААНБ-ын инженер техникийн ажилтантай тус тус хамтран төгсөлтийн үнэлгээг зохион байгуулсан.<br>Төгсөлтийн үнэлгээ болон диплом хамгаалалтад 251 оюутан, суралцагч үнэлэгдэж, | Хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог бүрдүүлэн ажил олгогч нарыг үнэлгээ хийх үйл ажиллагаанд татан оролцуулсан байна. | -2023-2024 оны хичээлийн жилийн МБС-ын 1 жилийн 6 мэргэжлийн 7 ангийн төгсөлтийн ур чадварын үнэлгээнд 5 ААНБ-ын 5 ИТА, ТБС-ын 1.5 жилийн 1 мэргэжлийн анги, 3 жилийн 2 мэргэжлийн ангиудын төгсөлтийн диплом хамгаалалтад 3 ААНБ-ын 3 ИТА оролцсон.<br>-2024-2025 оны хичээлийн жилийн Үйлдвэр дээрх дадлага болон Төгсөлтийн өмнөх дадлагын тайлан хамгаалалтанд “Шивээ-Овоо” ХК, “МАК Цемент” ХХК, “ОСО констракшин” ХХК, “Илчлэг шивээ” ХХК, “Петротрак” ХХК-ний, аймгийн Ойн анги “Баатарван транс” ХХК, “Альфа филтер” ХХК зэрэг байгууллагуудаас ажил олгогчийн төлөөлөл 5 мэргэжилтэн, 15 ИТА оролцож хамтран ажилласан. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төгсөгчдийн 68% нь ажлын байраар хангагдсан. | | | |
| **Зорилт 1.4. Нийгмийн түншлэлийн үйл ажиллагааг удирдлагаар хангах аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжлийн холбооны оролцоог дэмжих, гадаад, дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлэх, салбарын нэр хүндийг өсгөх;** | | | | | | |
| 1.4.1 | Төгсөгчдийг ажлын байртай болгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | Зохион байгуулалтын тоо: 2<br><br>Биелэлтийн хувь: 100<br><br>Аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогчидтой төгсөгчдийг холбож ажлын байранд зуучилж ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх. | 251 суралцагч 61 ААНБ дээр үйлдвэрлэлийн болон төгсөлтийн өмнөх дадлагыг 4-9 долоо хоногийн хугацаатай хийсэн. Төгсөлтийн үнэлгээ болон диплом хамгаалалтад 13 мэргэжлийн 251 оюутан, суралцагч үнэлэгдэж, 11 төгсөгч техникийн боловсрол сургалтын 1.5 жилд шатлан суралцаж байна. | Нийт төгсөгчдийн 65%-аас доошгүй хувь нь ажлын байраар хангагдсан байна. | 2023-2024 оны хичээлийн жилийн өвөл төгссөн МБС-ын 2.5 жилийн 80 төгсөгчөөс 24 төгсөгч ажлын байраар хангагдаж, 12 төгсөгч ТБС-ын 1.5 жилийн ангид, 2 төгсөгч их, дээд сургуульд шатлан суралцсан.<br>2023-2024 оны хаврын төгсөлтөөр төгссөн 83 төгсөгчөөс “Баатарвантранс” ХХК, “Альфа филтер” ХХК, “Петротрак” ХК, Төмөр замын Чулуун завод зэрэг 4 ААНБ-д ажиллах ажлын байрны урилгыг 17 төгсөгч авсан. | 100 |
| 1.4.2 | Элсэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр сурталчилгаа маркетингийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх | Хэрэгжүүлэх ажлын тоо: 4<br><br>Зохион байгуулсан үйл ажиллагааны хувь: 100<br><br>Үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллана. | 2023-2024 оны хичээлийн жилийн элсэлт 77 хувь буюу 276 оюутан, суралцагч шинээр элсэн орсон. 2023-2024 оны өвлийн төгсөлтөөр МБС-ын 2 мэргэжлийн төгсөгчид ТБС-ын 1.5 жилийн ангид шатлан суралцах элсэлтийг зохион байгуулна. | 2024-2025 оны хичээлийн жилийн элсэлтийг тоонд үндэслэн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна. | -2024 оны 04 дүгээр сарын 19-22-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Боловсролын шинэчлэл-2024” үзэсгэлэнд 2 багш, 1 ажилтан оролцож, байгууллагын дэлгэрэнгүй танилцуулгыг нийт 486 сурагч, эцэг эхэд танилцуулан УУНСО ангид 1, ЗБММО ангид 4 суралцагч бүртгэн авч 12 сурагч эцэг эхтэйгээ зөвлөлдөн нэмэлт мэдээлэл авсан. 2024-2025 оны элсэлтийн квотын дагуу элсэлт зохион байгуулах төлөвлөгөөгөөр 13 мэргэжлээр 361 сурацагч элсүүлсэн. 2025 оны 01 дугаар | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сард 30 суралцагч шатлуулан элсүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.<br>-Говьсүмбэр аймгийн ХХҮГ-тай хамтран “Нэг өрх-Нэг ажлын байр” Нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж аймгийн ажил мэргэжилгэй 150 өрхийн иргэдэд сурталчилгаа явуулж 17 хүнийг мэргэжил олгох сургалтанд хамруулсан. | |
| 1.4.3 | Багш-инженер солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх | Хэрэгжүүлэх ажлын тоо:2<br><br>Хамрагдах багш, ИТА: 5 багш, 3 ИТА<br><br>Хөтөлбөрийн биелэлтийн хувь: 100<br><br>Хамтран ажиллах гэрээтэй ААНБ-уудтай Багш-инженер солилцооны хөтөлбөр боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах. | Багш-Инженер солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд Шивээ-Овоо ХК, Мак цемент, Баатар Ван Транс ХК, Онцгой байдлын газар, БЗӨБЦТС ГСА салбар, Од ресорт амралтын газрын барилгын ажил дээр 16 багш, 16 ИТА-тай хамтран солилцооны хөтөлбөр хэрэгжүүлсэн.<br>Дээрхи ААНБ-д 76 оюутан, суралцагч дадлага хийж, мэдлэг ур чадвараа ахиулсан. | Багш-инженр солилцооны хөтөлбөрт хамрагдах багш, ИТА нарын тоо нэмэгдэж, мэргэжил мэдлэг дээшилж, сургалтын чанарт ахиц гарна. | 2024-2025 оны хичээлийн жилд “Шивээ Овоо” ХХК-руу уул уурхайн ашиглалтын 2 багш, Баяжуулалтын мэргэжлийн багш аймгийн барилгын материалын лабораторит хатаагуур, шигшүүр гэсэн 2 төхөөрөмж дээр тус тус 7 хоног, Санхүү эдийн засгийн багш мэргэжлийн дагуу “Шанд дов” ХХК дээр 2 сарын хугацаатай, Уул уурхайн ашиглалтын 1 багш Эрдэнэс таван толгойн “Баруун цанхийн уурхай”-д уулын инженерээр 2 сарын хугацаатай мэргэжлийн чиглэлээр дадлагажсан. | 100 |
| 1.4.4 | Дагалдан сургалт, үйлдвэр дээрх дадлагажих сургалтыг ажил олгогч, | Мэргэжлийн тоо: 4<br><br>Үйл ажиллагааны биелэлтийн хувь: 100 | МБС-н 395 суралцагч, ТБ-н 120 сургалтын оюутан нийт 87 аж ахуйн нэгж | Сургалтын чанарт ахиц гарч багш, оюутан нарын ур чадвар дээшлэн оюутануудын ур | “Баатарван транс” ХК, “Шанддов” ХХК дээр хамтран ажиллах гэрээ дагуу 3 чиглэлээр 20 суралцагч, 2 багш дадлагажсан.<br>ТБ-ын 2, 3 дугаар курсийн 85 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | чадамжийн төвтэй хамтран зохион байгуулах | Мэргэжлийн багш, оюутан суралцагч нарын ур чадвар дээшлэх. | байгууллага дээр танилцах, үйлдвэрлэлийн, төгсөлтийн өмнөх дадлага хийсэн. “Зам барилгын машин механизмын чадамжийн төв”-ийн машин механизм дээр дадлагажих сургалтыг Налайх дахь Политехник коллежтой хамтран зохион байгуулж сургалтад мэргэжлийн 3 багш хамрагдсан. | чадварын зөрүү арилж ААНБ-уудад ажлын байранд гарахад бэлэн болсон байна. | суралцагч, МБ-ын 2,5 жилийн 186 суралцагч үйлдвэрлэлийн болон танилцах дадлагыг хамтран ажиллагч байгууллагууд дээр хийж тайлан хамгаалалтанд бүрэн хамрагдсан. | |
| **Зорилт 1.5. Байгууллагын хүний нөөцийн удирдлага, багшийн хөгжлийг тасралтгүй хангах, чадавхыг бэхжүүлэх, сургалтын байгууллагын менежментийг сайжруулах, хөгжүүлэх;** | | | | | | |
| 1.5.1 | Сургуулийн бүтэц, орон тоо, төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулах | Тоо:12 сар<br><br>Чанар: Сар бүр төсвийг зориулалтын дагуу зарцуулна. | 2023 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулж, өр авлага үүсгэлгүй ажилласан. | Хэмнэлтийн горимын дагуу төсвийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зүй зохистой зарцуулж өр авлага үүсгэлгүй ажиллана. | Цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор 85,950,000 төгрөгийн НДШ, ХАОАТ-ын өр үүссэн. Өр авлагын талаарх мэдээллийг холбогдох газарт хүргүүлсэн. 2024 оны 12 дугаар сарын 20-ны дотор барагдуулж дууснa. | 100 |
| 1.5.2 | Цалин, урамшууллын оновчтой хэлбэрийг тогтоож, үр бүтээлтэй ажиллах хөшүүргийг бий болгох | Тоо: 4 удаа<br>Чанар: Цалин, урамшууллын оновчтой хэлбэрийг тогтоож, үр бүтээлтэй ажиллах хөшүүргийг бий болгон улирал бүр ажлын үзүүлэлтийг үнэлэж ажиллана. | Багш, ажилтныг үнэлэх журмыг шинэчлэн боловсруулж, батлуулан биелэлтийг хангаж ажилласан. | Засгийн газраас гаргасан цалин хөлс, урамшуулалтай холбоотой хууль, тогтоомжийн биелэлтийг хангaн ажиллана. | 2024 оны 11 дүгээр сарын байдлаар багш, ажилчдад 57,666.000 төгрөгийг хоол, унаанд, 183,572.138 төгрөгийг илүү цагт, 132,904.090 төгрөгийг танхимын бус цагт, 79,641.165 төгрөгийг үр дүнгийн урамшуулалд, 103,717.074 төгрөгийг алба хаасны нэмэгдэлд, 82,119.612 төгрөгийг ур чадварын урамшуулалд, | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 39,810.118 төгрөгийг мэргэжлийн зэргийн нэмэгдэлд, 39,810.118 төгрөгийг хөдөө орон нутагт ажилласны нэмэгдэлд тус тус олгосон.<br>3 болон 5 жил тутамд нэг удаа олгодог тэтгэмжийг 17 багш, ажилтанд 150,399,000 төгрөгийг олгосон байна. | |
| 1.5.3 | Улс, бүс, орон нутгийн хэмжээнд ерөнхий эрдмийн болон мэргэжлийн ур чадварын уралдаан, тэмцээн, олимпиад оролцох | Хэрэгжүүлэх ажлын тоо: 6<br>Чанар: ЕБС-ын стандарт хангалт, ур чадварын түвшин ахина. Мэргэжлийн ур чадварын тэмцээнд оролцож ур чадвараа дээшлүүлнэ. | Улс, орон нутаг, сургуулийн хэмжээнд зохион байгуулагдсан ур чадварын уралдаан, олимпиадад дараах амжилтыг үзүүлсэн. Үүнд:<br>Улсын ур чадварын уралдаан болон олимпиадад 3 багш, 5 суралцагч, аймгийн олимпиадад 1 багш, сургуулийн ур чадварын уралдаанд 3 мэргэжлээр 95 суралцагч | Мэргэжлийн ур чадварын уралдаан, тэмцээн олимпиадад оролцож, амжилтаа ахиулж, олимпиад, уралдаан, тэмцээнд бэлтгэж давтлага хичээл өгсөнөөр суралцагч нарыг мэдлэг ур чадвар дээшилсэн байна. | Хүнс технологийн политехник коллежийн нэрэмжит “Шилдэг илтгэл-2024” Улсын илтгэлийн уралдааны 1 дүгээр шатны шалгаруулалтанд 1 багш, 2 суралцагч “Өсвөр үеийнхний цахим хэрэглээ, өнөөгийн байдал” сэдвээр илтгэлийн бичвэрээ цахимаар явуулсан.<br>04 дүгээр сарын 22-нд эхний шатны шалгаруулалтын дүн гарч 2 дугаар шатны шалгаруулалтанд 3 суралцагч амжилттай оролцсон. Барилгын Политехник коллежоос зохион байгуулсан “Нийгмийн ухааны улсын анхдугаар олимпиад”-д 2 багш, 5 суралцагч, МСПК-ын зохион байгуулсан Автомашины засварын мэргэжлийн багш, суралцагч нарын дунд зохион байгууллагдсан ур чадварын уралдаанд 1 багш 4 суралцагч, ТТПК-ын зохион байгуулсан Гагнуурын мэргэжлийн ур чадварын уралдаанд 1 багш 1 суралцагч тус тус амжилттай оролцсон. 2024 оны 12 сарын 11-нд сургуулийн ур чадварын уралдааныг МБ-ын Гагнуур, Механикжсан тээврийн хэрэгсэл | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | механизмын засвар үйлчилгээ, Цахилгаан хангамж тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ мэргэжлийн 2,3 дугаар курсын суралцагчдын дунд зохион байгуулна. Мөн МБС-ын 1,2 дугаар курсын суралцагчдын дунд ерөнхий эрдмийн 6 хичээлээр олимдиад зохион байгуулсан. | |
| 1.5.4 | “Багшийн хөгжил” хөтөлбөрийг багш нарын оролцоотойгоор боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллах | Хэрэгжүүлэх ажлын тоо:1<br>Хамрагдах багшийн тоо: 38<br>Чанар: “Багшийн хөгжил” хөтөлбөрийг сайжруулан боловсруулж, хэрэгжилтийг хanган ажиллана. | Говьсүмбэр аймгийн БШУГ болон БШУЯ-аас зохион байгуулсан “Үндэсний бичгээр цахимд бичих арга зүй сургалтад 2 багш, ажилтан, “Lingors education institute”-ээс зохион байгуулсан боловсролын салбарын багш, ажилчдын англи хэл суралцахуйг дэмжсэн “English Reading Teachers 2023” гурван шатлалт хөтөлбөрт 9 багш, Бичиг соёл төвөөс зохион байгуулсан “Хулсан үзгийн бичиг” сургалтад 2 багш, ажилтан, Learning English perfectly сэдэвт МУИС-ийн судлаач багш Намхайжанцанг ийн сургалтад 35 | Багшийн хөгжил хөтөлбөрийг “Багш хөгжлийн төв”-өөр дамжуулан хэрэгжүүлж багш ажлын байран дээр болон бусад захиалгат болон төлөвлөгөөт сургалтаар хөгжих боломж нөхцөлийг хангаж хэрэгжүүлсэн байна. | 3 тэнхимийн 39 багш, багш нарын зөвлөлтэй хамтран “Багш өөрийгөө хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө боловсруулан батлуулсан. Төлөвлөгөөг нэгтгэж, сургуулийн “Багш хөгжил 2025” төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Доктрант 1, бакалаврт 2 мэргэжлийн багш боловсролын зэргээ дээшлүүлж байна. Ерөнхий эрдмийн 3 багш МУБИС-д дахин мэргэжил эзэмшихээр төлөвлөгөөндөө тусгасан. Ерөнхий эрдмийн 3 багш олимдиад, ЕШ-д суралцагч бэлтгэх арга зүй чиглэлээр 90 цагийн цахим сургалтад суусан. Ажлын байран дээр Монгол бичгийн анхан, дунд, ахисан шатны сургалтад 36 багш хамрагдаж байна. Хичээлийн төлөвлөлт арга зүйн сургалтад 36 багш хамрагдсан. УБ хотод Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслөөс зохион байгуулсан Мэргэжлийн болон техникийн | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | багш, Мэргэжлийн боловсрол сургалтын Залуучуудын хөгжлийн зөвлөлөөс зохион байгуулсан “МБС-ын байгууллагын ялгаатай хэрэгцээтэй суралцагчидтай ажиллах арга зүй” СЗСҮТ-ийн МБУЧОС-ийн тусгай хэрэгцээт боловсролын багш, сэтгэл судлалын докторант Б.Уянгын удирдан явуулсан сургалтад 10 багш, БЕГ-аас зохион байгуулсан “Үнэлгээний ажилтан” бэлтгэх Модуль-1 сургалтад 8 багш, Модуль-2 сургалтад 1 ажилтан, Модуль-4 сургалтад 3 багш, Үнэлгээний төрөл, арга зүйн сургалтад 13 багш. Нийт 9 төрлийн сургалтад 82 багш хамрагдсан. | | боловсролын сургалт (МБТБС)-ын мэргэжлийн чиглэл, индексийн хэрэгжилтийг хангах хөтөлбөр боловсруулах сургалтад ХММ-ын 3, цахилгааны 2 багш хамрагдсан. | |
| 1.5.5 | Сургалтын хэрэгцээг тодорхойлох, сургалт зохион | Хамрагдах сургалтын тоо: 5 Хэрэгжүүлсэн ажлын хамрагдалтын | Багш ажилчдын сургалт, хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, нийт | Сургалтын хэрэгцээг тодорхойлж, багш ажилчдыг 5-аас доошгүй буюу багш, | Багш, ажилчдаас сургалтын хэрэгцээний судалгаа авч сургалтад хамруулан ажиллаж байна. БМДИ-ээс зохион | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах, сургалтад хамруулах | биелэлтийн хувь: 100% Нийт багш ажилтан нарын сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа авч түүнд үндэслэн төлөвлөгөө боловсруулан сургалт зохион байгуулж, үр өгөөжийг тооцсон байна. | 83 багш ажилтнаас 35 багш, ажилтан ажил, мэргэжлийнхээ дагуу 2-5 удаагийн мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, давхардсан тоогоор нийт 420 багш, ажилтан ГСА-ийн Цагдаагийн хэлтэс, ГБХЗХГ, Музей, Онцгой байдлын газар болон бусад байгууллагаас зохион байгуулсан хууль эрхзүй болон соён гэгээрүүлэх сургалтад цахим болон танхимаар тус тус хамрагдсан. | ажилтныг 100% сургалтад хамруулж, мэдлэг ур чадвар сургалтын чанарт ахиц гарсан байна.. | байгуулдаг 10 дахь жилийн үндсэн сургалтад Ерөнхий эрдмийн 3 багш, менежерүүдийн 5 дахь жилийн сургалтад 1 арга зүйч тус тус хамрагдсан. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан бичих сургалтад 2 мэргэжлийн ажлын хэсгийн давхардсан тоогоор 24 багш, ажилчид цахимаар хамрагдсан. Эко зөвлөлийн 5 гишүүн Ногоон туг авахад шаардагдах нотолгоо бүрдүүлэх материал дээр ажиллах арга зүйн сургалтад хамрагдсан.<br>2025 оноос төрийн албан бичиг монгол бичгээр бичих болсонтой холбоотойгоор 3 түвшинд 79 багш ажилчид ажлын байран дээр суралцаж байна.<br>ХГБХГ-аас улсын байцаагч Хоролгарав “Хүүхэд хамгааллын тухай хууль” сургалтыг 35 багш, ажилтан, Аймгийн хүний эрхийн комиссын референт Наранбаатар, Сувд нар “Ажлын байрны дарамт”, “Ажлын байрны бэлгийн дарамт” сургалтад тус тус 45 багш, ажилтан нар тус тус хамрагдсан. | |
| 1.5.6 | Багшийн ёс зүй, дээшлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах | Сургалтын тоо: 4 удаа<br>Зохион байгуулсан сургалтын биелэлтийн хувь: 100%<br>Сургалтуудыг улирал бүр үе шаттай зохион байгуулна. | 2023 оныг ёс зүйн жил болгон зарласантай холбогдуулан багш, ажилчдад 4 төрлийн сургалтыг Аймгийн Прокурорын газар, Цагдаагын хэлтэс, Нэгдсэн | Багшийн ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэхээр улиралд 1 удаа сургалт зохион байгуулж, багшийг багшаар үнэлүүлэх, оюутан, суралцагчдаас сэтгэл ханамжийн | Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан “Багшийн ёс зүй, багшийн ёс суртахуун” сэдэвт сургалтад 32 багш, 6 арга зүйч, 1 албаны менежер, МБС-н залуучуудын зөвлөлөөс зохион байгуулсан “Албан харилцааны ёс зүй, хамтын ажиллагаа” сэдэвт цахим сургалтад 2 багш, ажилтан, Аймгийн ХГБХГ-аас “Хүүхэд | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | эмнэлэгийн Ёс зүйн хорооны дарга Будханд, Эрүүл мэндийн газрын Ёс зүйн хорооны Өлзий-Тогтох нартай хамтран зохион байгуулсан. Давхардсан тоогоор 288 багш, ажилтан хамрагдсан. Оюутны дотуур байранд амьдарч байгаа 131 оюутан суралцагчаас сэтгэл ханамжийн судалгааг авч, ёс зүйтэй багш, ажилтан нэг нэг хүнийг шагнаж урамшуулсан. Ажилтны ёс зүйтэй холбоотой 3 гомдол ирснийг цаг хугацаанд нь шийдвэрлэсэн. 2023 оны 9 сард Ёс зүйн хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй шинээр зохион байгуулж ёс зүйн хорооны ажиллах дүрэм журмыг боловсруулан батлуулсан. | судалгаа авч, ёс зүйтэй багшийг шагнан урамшуулахаар байгууллагын дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. | хамгааллын ёс зүйн" сургалтад, Байгууллагын ёс зүйн дэд хорооноос "Ёс зүйн харилцаа хандлага" сургалтад тус тус 79 багш ажилтан, Байгууллагын ёс зүйн дэд хорооноос "Төрийн албан хаагчийн ёс зүй", "Ёс зүйн тухай хууль", "Мэргэжлийн ёс зүй" сэдвээр шинээр ажилд орсон 7 багш, ажилтанд, АЗДТ-аас зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал" сургалтад 1 удирдлага, ёс зүйн дэд хорооны 4 гишүүн, "Хувь хүний хөгжил, хандлага", ёс зүйн" сэдвээр 3 цагийн сургалтад 60 багш, ажилтан, СӨБ, ЕБС, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүд, удирдах ажилтны цахим сургалтад захирал, сургалтын албаны менежер, сургуулийн ёс зүйн дэд хорооны 8 гишүүн хамрагдаж, 3 түвшиний үнэмлэхийг нийт 10 багш, ажилтан авсан. | |
| 1.5.7 | Багш, ажилчдыг ажлын байран дээрээ хөгжих | Хэрэгжүүлэх ажлын тоо: 4 | Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, шинэ | 4 багш, ажилтан бакалавр, магистрын дипломтой болсон | 3 тэнхимийн 39 багш, багш нарын зөвлөлтэй хамтран "Багш өөрийгөө хөгжүүлэх урт, дунд, | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | нөхцлийг бүрдүүлэх | Хамрагдалтын биелэлтийн хувь: 100<br><br>Багш ажилчдыг өөрийн эзэмшсэн мэргэжлээр бакалавр магистрын сургалтад хамрагдах үйл явцад дэмжлэг үзүүлэх. | техник технологи, хөдөлмөр зохион байгуулалтын дэвшилтэд арга барил судлах, харилцан туршлага судлах зорилгоор "Багш, оюутан солилцооны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхээр 4 коллеж, 3 их дээд сургуульд хүсэлтээ уламжилсан. 2022 оноос хойш Боловсрол, эрхзүйн дээд сургууль, ХААИС-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд 3 ажилтанг магистрт тэтгэмжтэй чөлөө, ШУТИС-д 1 багш докторантурт, ҮТИС-д мэргэжлийн 2 багш бакалаврт хамтран ажиллах гэрээний хүрээнд 30 хувийн хөнгөлөлттэй суралцаж байна. Нийт 5 сургалтын байгууллагад 9 багш, ажилтан, оюутан хөнгөлөлттэй болон шатлан суралцаж байна. | байна. | богино хугацааны төлөвлөгөө" боловсруулан батлуулсан. Төлөвлөгөөг нэгтгэж сургуулийн "Багш хөгжил 2025" төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Доктрант 1, бакалаврт 2 мэргэжлийн багш суралцаж байна.<br><br>Ерөнхий эрдмийн 3 багш МУБИС-д дахин мэргэжил эзэмшихээр хүсэлт өгсөн.<br><br>Ерөнхий эрмдийн 3 багш олимдиад, ЕШ-д суралцагч бэлтгэх арга зүй чиглэлээр 90 цагийн цахим сургалтад хамрагдсан.<br><br>Хичээлийн төлөвлөлт арга зүйн сургалтад 36 багш хамрагдсан.<br><br>"Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь" төслөөс зохион байгуулсан Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалт (МБТБС)-ын мэргэжлийн чиглэл, индексийн хэрэгжилтийг хангах хөтөлбөр боловсруулах сургалтад ХММ-ын 3, цахилгааны 2 багш хамрагдсан. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.5.8 | Сургалтын сурах бичиг, гарын авлага, хэрэглэгдэхүүнийг сайжруулах, шинээр боловсруулах | Хэрэглэгдэхүүний тоо: 6 төрлийн 120 ширхэг<br><br>Хэрэгжилтийн биелэлтийн хувь: 100<br><br>Сургалтын хэрэглэгдэхүүний нийтлэг шаардлагад нийцсэн байх. | Ерөнхий эрдэмийн 3 бүлгийн 41 багц 410 ширхэг ном, мэргэжлийн 2 төрлийн 13 ном. Тогтмол хэвлэлийн 1 төрлийн 40 ширхэг ном хэвлэл, 43 төрлийн 463 номоор номын фондыг нэмэгдүүлсэн. | Сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг, гарын авлагын тоо, хувь хэмжээ, нэмэгдэн сургалтын чанарт ахиц гарсан байна. | Хөдөлмөрийн аюулгүй байдлын менежмент хичээлийн гурван бүлэг сэдвийн хүрээнд:<br>1. ХАБЭА-н тогтолцоо<br>2. Аюулгүй байдлын удирдлага<br>Эрсдэлийн менежмент гэсэн 3 төрлийн гарын авлага шинээр боловсруулсан.<br>Ерөнхий эрдмийн 10-р ангийн 9, 11-р ангийн 9, 12-р ангийн 8 багц ном нийт 342 ширхэг 2,287,400 төгрөг, мэргжлийн холбогдолтой 1 төрлийн 250,000 төгрөгийн ном худалдан авалт хийж нийт 343 ширхэг номоор фондын баяжилт хийсэн. | 100 |
| 1.5.9 | Гадаад харилцааны хамрах хүрээ, үйл ажиллагааг өргөжүүлэх, хамтын ажиллагааны гэрээ байгуулах | Сургалтын байгууллагын тоо: 1 сургалтын байгууллага<br>Зохион байгуулагдсан ажлын биелэлтийн хувь: 100%<br>БНСУ-ны Тэгү хотын ажил мэргэжлийн сургуультай хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллана. | БНХАУ-ын ӨМӨЗО-ны ажил мэргэжлийн сургуультай хамтран ажиллах санамж байгуулан шалгуурын дагуу 3 оюутанг 5 жилийн хугацаатайгаар 100 хувийн тэтгэлэгтэй, 2200 юанийн тэтгэмжтэйгээр суралцуулах, 2 удирдах ажилтан, 1 ажилтан, 3 багшийг туршлага судлуулахаар бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна. ӨМӨЗО-ны АМС-аас зохион байгуулсан сургалтанд | 15-аас доошгүй багш ажилтанг туршлага судлуулж, дадлагажуулсан байна. | Бүгд Найрамдах Солонгос Улсын Тэгү хотын ажил мэргэжлийн сургуультай танилцах, туршлага судлах аялалд 2 удаагийн давтамжтайгаар 18 багш, ажилтан хамрагдаж, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр багш, оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх талаар санал солилцсон.<br>БНСУ-ын Шинхан технологийн их сургуулийн захирал удирдлагууд манай сургуультай танилцаж хамтраж ажиллах гэрээ байгуулж оюутан солилцоо болон цахимаар хэлний бэлтгэлд хамруулахаар болсон. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэргэжлийн 2 багш, БНСУ-ын Бусан, Дэгү хотын ПК-той хамтран ажиллах гэрээ байгуулах, туршлага судлахаар 12 дугаар сард 15 багш ажилтаны бүрэлдэхүүнтэй явах ажлыг Вэнус меди тур ХХК-тай хамтран бэлтгэл ажлыг хангаж ажилласан. | | | |
| 1.5.10 | Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, дэмжих. | Хэрэгжүүлэх ажлын тоо: 2<br><br>Биелэлийн хувь: 100<br><br>Хүн бүр ураг удмаа мэдэж, өрх бүр угийн бичгээ хөтлөх ажлыг хэрэгжүүлэх. | Нийт багш, ажилтны 12 хувь нь угийн бичгийг хөтлөж байна. | Угийн бичиг хөтлөх аяныг үе шаттайгаар зохион байгуулсан байна. | Угийн бичгийн сургалтыг хоёр үе шаттай зохион байгуулж, сургалтад 83 албан хаагч 100% хамрагдаж, угийн бичиг бичих ойлголтыг авсан. Дараагийн шатны сургалт хүртэл гэрийн даалгавраар өөрийн дээш доош 3 үеэ судлах ажлыг эхүүлээд байна. 79 багш, ажилтан хамрагдсанаас 17 нь зураглал, 2 нь шаштираа бичсэн үр дүн гарсан. | 100 |
| 1.5.11 | Цахим сургалтын платформ, сургалтын хөтөлбөр, агуулга, хичээл боловсруулан суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ. | Тоо:10 төрөл, 100 цахим хичээл<br>Чанар: Цахим заах арга зүйн уралдаан тэмцээн явуулан сургалт зохион байгуулах арга зүйгээр ханган ажиллана. | - | Цахим сургалтын орчин бүрдэнэ. Цахим хичээлийн сан нэмэгдэж, цахим номын сан, бие даалтын сан, дипломын ажлын сан бүрдэж дотоод сүлжээнд байршсан байна. 3 интеграци хичээлийг боловсруулсан байна. | Canva программ дээр 108 хичээл, Postermywall -20, focusky -3, Genially программ -5, Flipsnack-15, Plickers -6, Storyjumper дээр 108, Bookweidgh-10, powerpoint интерактив хичээл -15 цахим хичээл тус тус хийсэн. ХАБЭА-н 5 хичээлийн цахим хичээл хийж, Classroom ашиглаж цахим сургалт зохион байгуулах арга зүйн сургалтад 13, цахим хичээл хийх сургалтад 35 багш, "Копьютерийн хэрэглээний | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | программ дээр хэрхэн зөв ажиллах", "Photoshop программ дээр ажиллах" анхан шатны арга зүйн сургалтад нийт 36 багш хамрагдсан. Цахим хичээлийн сан бүрдсэн. Багшийн мэдлэг, программ дээр ажиллах ур чадвар дээшилсэн. Сургалтад хамрагдсан багшийн тоо, давхардсан тоогоор 84. Цахим хичээлийн тоо 292. | |
| **Зорилт 1.6. Суралцагч, төгсөгчдийн хандлага, төлөвшил, зан үйлийн харилцаанд эерэг өөрчлөлтийг бий болгоход чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах;** | | | | | | |
| 1.6.1 | Энтрепренёр шип, өөрөө өөртөө ажлын байр бий болгох боломжийг нэмэгдүүлэн, төгсөгчдийг чиглүүлэх, дэмжих үйл ажиллагааг сайжруулж, гарааны компани эрхлэх нөхцлийг бүрдүүлэх | Төслийн тоо: 1<br>Төслийн биелэлтийн хувь: 100%<br>Багш, оюутнуудыг ESEL сургалтад хамруулан төсөл хөтөлбөрт хамрагдах боломжийг нь хангаж ажилласан байна. | Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, Энтрепренершипий н боловсрол олгох" төслийн хүрээнд PICH DAY-6 өдөрлөгт 72 оюутан нийт 19 төсөл боловсруулан оролцож 2-р шатанд 15 төсөл шалгарсанаас 9 төсөл дэмжигдэж 31.500.000 төгрөгийн хөрөнгө оруулалт авч төсөл хэрэгжсэн. | 20 оюутанг төслийн сургалтад хамруулж, 5-аас доошгүй төслийг хэрэгжүүлсэн байна. | 2023-2024 оны хичээлийн жилийн намрын ESEL сургалт 43 цагийн танхимын хичээл, 23 цагийн танхимын бус цагийн хичээл нийт 66 цагийн сургалтад 24 суралцагч хамрагдсан. 24 суралцагч 4, 4-н суралцагчийн бүрэлдэхүүнтэй 7 төсөл бичиж, PITCH DAY өдөрлөгт оролцохоор багууд сургалт, судалгааны явцад орон нутгийн биенес эрхлэгчээс авсан зөвлөгөө, зөвлөмжийн дагуу төслөө бичиж эхэлсэн. БЕГ-ийн мэргэжилтэнүүд манай аймагт ажиллаж, төслийн үйл ажиллагаа болон төслийн явцтай танилцсан. Улсын хэмжээний сургагч багш бэлтгэх сургалтад манай сургуулийн 3 багш сургалт болон түгээн дэлгэрүүлэлт хийж, 1 багш мастер багш, 2 багш сургагч багш болсон. | 100 |
| 1.6.2 | Суралцагчдын бие бялдар, харилцаа хандлага, зөв | Сонгон, секц, дугуйлангийн тоо: 10<br>Үйл ажиллагааны биелэлтийн хувь: | 2023-2024 оны хичээлийн жилд 15 төрлийн сонгон, секц, дугуйлан, | Бие бялдрын сорил, зөв төлөвшил, харилцаа хандлагын талаар өөрчлөлт | 2023-2024 оны хичээлийн жилд "Оч" өсвөрийн аврагч бүлгэмийг нийт 25 хүүхэд сонгон суралцаж, эмнэлгийн анхан шатны тусламж | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төлөвшил бий болгох арга хэмжээг зохион байгуулах | 100%<br>Нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | клубт 550 оюутан суралцагч хамрагдсан. | гарсан байна. | болон гамшгийн үеийн бэлэн байдалд суралцсан.<br>Долоо хоногт 1 удаа 80 минутаар суралцагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, зөв хандлага харилцааг бий болгох арга хэмжээг 1 сарын хугацаанд зохион байгуулж, нийт 220 суралцагч хамрагдсан.<br>Бие бялдарын сорилыг 1 удаа 6 үзүүлэлтээр авсан. Энэ сорилд 360 суралцагч хамрагдсан.<br>Энэ хичээлийн жилд 11 төрлийн сонгон, секц, дугуйлан, клубт 216 суралцагч хамрагдсан. 2024 оны 10 сард МБС-ын 3 жилийн 1 дүгээр курсын 114 суралцагчдын бие бялдарын сорилыг авч, программд мэдээллийг оруулсан. Өсвөрийн аврагч бүлгийн 15 суралцагч “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг” сургалтад хамрагдсан. | |
| 1.6.3 | Хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд суралцагчийн эрх ашгийг хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх нийгмийн халамж үйлчилгээг үзүүлэх | Ажил үйчилгээний тоо: 8<br>Зохион байгуулагдсан ажлын биелэлтийн хувь: 100%<br>Суралцагчийг бүх төрлийн дарамт, хүчирхийллээс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байна. | Хүүхэд хамгааллын чиглэлээр 8 төрлийн ажил үйлчилгээ хийгдэж нийт давхардсан тоогоор 330 оюутан хамрагдсан.<br>Сэтгэл зүйн зөвлөгөөнд 2 оюутан хамрагдсан. | Суралцагчийн эрх ашгийг хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх нийгмийн халамж үйлчилгээг үзүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Хүүхэд хамгааллын чиглэлээр 2 төрлийн ажил үйлчилгээ хийгдэж, нийт давхардсан тоогоор 425 оюутан хамрагдсан.<br>ГСА-ийн Нэгдсэн Эмнэлэгийн сэтгэцийн эмч Хэрлэнгээс 3 оюутан сэтгэл зүйн зөвлөгөө, ЕБС-ийн 5 дугаар сургуулийн хоол зүйч Д.Оюунцэцэгээс өсвөр үеийн эрүүл зохистой хооллолтын зөвлөгөөг 4 оюутан тус тус авсан.<br>Оюутнууддаа эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй үзүүлэх зорилгоор нийт 81 төрлийн 1.806.930 төгрөгний анхан шатны | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эм, эмнэлгийн хэрэгслээр хангаж, нийт давхардсан тоогоор 659 багш, ажилтан, оюутан сурагчдад үйлчилгээ үзүүлсэн. Үүнд: эм-458, тариа дусал-265, бумба, бариа-35, боолт-19<br>Хүүхэд хамгааллын баг байгуулан захирлын тушаалаар баталгаажуулсан.<br>Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг, хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм, нууцлалын гэрээг боловсруулан, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагчаар хянуулан сайжруулж, баталгаажуулсан.<br>Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг, хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм, нууцлалын гэрээг бүх багш ажилчидтай байгуулан баталгаажуулж батламж гардуулсан. | |
| 1.6.4 | Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хүүхэд хамгааллын чиглэлээр нөлөөллийн болон зорилтот сургалтуудыг зохион байгуулах | Нөлөөллийн ажлын тоо: 10<br>Зохион байгуулагдсан ажлын биелэлтийн хувь: 100%<br>Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээний хөтөлбөр, сургалт зохион байгуулах хэрэгцээний судалгаа гарган төлөвлөгөө боловсруулж, ажиллана. | “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийг нээж, төлөвлөгөөгөө боловсруулан ажиллаж байна.<br>471 оюутан суралцагч “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “БЗДХӨ түүнээс сэргийлэх арга зам”, “Гэр бүл төлөвлөлт”, “Осол гэмтэл хүчирхийллээс сэргийлэх нь”, “Үе | Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран нөлөөллийн болон зорилтот сургалтуудыг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган давхардсан тоогоор 450 суралцагчийг хамруулсан байна. | 2024 онд давхардсан тоогоор 1500 оюутанд дараах сургалтуудыг явуулсан. Үүнд:<br>-ЕБС-н 5 дугаар сургуулийн хоол зүйч Д.Оюунцэцэгтэй хамтран “Өсвөр үеийн зүй зохистой хооллолт” сэдэвт сургалт, дадлага<br>-Эко сургууль хөтөлбөрийн хүрээнд “Ус-Чандмань эрдэнэ” сэдэвт сургалт<br>-Аймгийн ОБГ, СОК, ЗДТГ-н Японы хүүхдийг ивээх сангийн төслийн багийнхантай хамтарч “What3words” application-ны сургалтыг 550 оюутанд, “What3words” application-ны REEL- | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тэнгийн дээрэлхэлт болон цахим дээрэлхэлтээс сэргийлэх нь", "Скутер, унадаг дугуй, мопед, мотоциклоор замын хөдөлгөөнд оролцоход анхаарах асуудал" "Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмж" сургалт нөлөөллийн ажилд хамрагдсан байна. | | 2 ширхэг, дадлага сургуулалтыг Аймгийн шуудан холбооны газартай хамтран зохион байгуулж, 10 долоо хоногийн турш зохион байгуулагдсан аянд аймагтаа "1-р байр"-нд шалгарсан.<br>-ЦЕГ-тай хамтран "Хар тамхи мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалт,<br>-"Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй" сэдэвт сургалт, нөлөөллийн ажил,<br>-"Цахим орчны халдлагаас урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалт,<br>-Аймгийн ХГБХГ-тай хамтран өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн ЭМ-н цогц боловсрол олгох сургалт, сургагч багш бэлтгэх сургалтуудыг тус тус зохион байгуулж, хамтарч ажилласан.<br>-Цагдаагийн хэлтсийн Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран Хүүхэд хамгааллын тухай хууль, түүний хэрэгжилтийн талаар 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан.<br>-"Охидын өдөрлөг 2024" арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд Өрхийн эмнэлэг, ГСАЭМ-ийн газрын мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, "ANGEL CLINIC" эмэгтэйчүүдийн эмнэлэгийн эмч, Аймгийн манлайлал болсон залуу бизнесмен, АИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид, 56 эмэгтэй суралцагч хамрагдсан.<br>-Хүүхдийн эрхийн улсын байцаагчийг урьж, "Хүүхэд | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамгааллын тухай хуулийн шинэчлэл, бодлогын хэрэгжилт" сэдвээр 4 удаагийн сургалт,<br>-"Тамхины хяналтын тухай хууль, тамхины хор хөнөөл" сэдвээр МБС-ын 1 дүгээр курсын оюутан суралцагчдад сургалтыг зохион байгуулж, 65 суралцагч хамрагдсан бөгөөд сургалтын үеэр 5 суралцагч тамхинаас гарахаа бүх оюутан, суралцагчдын өмнө зарлан мэдэгдэл хийсэн.<br>-Оюутан суралцагчид Говьсүмбэр аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Хүүхэд өсвөр үеийг ивээх төв төрийн бус байгууллагатай хамтран Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох газраас зохион байгуулсан 2 өдрийн сургалтад хамрагдсан.<br>Японы хүүхдийг ивээх сангийн Esel хөтөлбөрт хамрагдсан оюутнууд Pitchday-7 төслийн уралдаанд "Хадгалагч", "Уран гартнууд" гэсэн 2 төсөл бичиж, санхүүжилтээ авсан.<br>"Эрүүл орчин—Эрүүл хүүхэд" нөлөөллийн ажлын хүрээнд "Орчны эрүүл мэнд", "Парламентын боловсрол" сэдэвт сургалтыг зохион байгуулсан.<br>-Эко зөвлөлийн гишүүд БЗӨБ-ийн Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Говьсүмбэр аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлтэй хамтран "Эрчим хүчээ хэмнэж эх дэлхийгээ хамгаалъя" сэдэвт сургалтад дотуур байрны 92 оюутан | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | суралцагч хамрагдсан.<br>-Сургуульдаа тавтай морил" өртөөчилсөн аялал сургалтад шинээр элсэн орсон 361 суралцагч хамрагдсан.<br>-"Уур амьсгалын өөрчлөлт ба монгол" хамтарсан арга хэмжээний сургалт, үйл ажиллагааг 1 дүгээр курсын 150 оюутан суралцагчдад зохион байгуулсан. | |
| 1.6.5 | Онцгой хэрэгцээ шаардлагатай суралцагчдад зориулсан орчныг бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх. | Хийгдэх ажлын тоо: 2<br><br>Биелэлтийн хувь: 100<br><br>Хөгжлийн бэрхшээлтй болон онцгой хэрэгцээтэй иргэд сурч боловсрох орчин нөхцөлөөр хангагдах. | - | **Эхний хагас жилд:** Дээд шатны өрийн байгууллагуудтай хамтран онцгой хэрэгцээ шаардлагатай иргэдийг судалгааг авч төлөвлөгөө боловсруулсан байна.<br>**Жилийн эцэст:** Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна. | 2024-2025 он хичээлийн жилд Эко сургууль хөтөлбөрийн хүрээнд 00-ын өрөөг тохижуулан ажилласан.<br>Нийгмийн ажилтан хөгжлийн бэрхшээлтэй болон онцгой хэрэгцээт 11 оюутан, суралцагчдын судалгааг гарган ажиллаж байна. Хэрэгцээ шаардлагын дагуу хичээл сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, анги танхимын, стандартад шинчлэл хийж ажилласан | 100 |
| 1.6.6 | Оюутны эцэг эхийн зөвлөгөөнийг зохион байгуулах | Зөвлөгөөний тоо: 2<br><br>Биелэлтийн хувь: 100<br><br>Багш, суралцагч, эцэг эхийн гурвалсан харилцаа холбоог сайжруулах. | - | Зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, 70 эцэг эх, 70 суралцагчийг хамруулсан байх. | 2023-2024 оны төгсөлт, 2024-2025 оны хичээлийн жилийн нээлтийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 132 эцэг эх оролцон сургуулийн үйл ажиллагаатай танилцаж зөвлөгөөнд оролцож эцэг эх асран хамгаалагч оюутанууд АУБ гурван талт гэрээг, Оюутаны дотуур байранд амьдрах гэрээг байгуулсан. | 100 |
| 1.6.7 | Суралцагчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулах | Даатгалын тоо: 1<br><br>Даатгуулах оюутны тоо: 350 | - | 2024-2025 оны хичээлийн жилд шинээр элсэн орж байгаа оюутан | Гэнэтийн ослын даатгалд 256 оюутан суралцагчдыг 880,000 төгрөгөөр Мөнх даатгалд даатгуулсан. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Даатгалын биелэлтийн хувь: 100<br><br>Болзошгүй аюулаас өөрийгөө хамгаалах чадварт суралцах | | суралцагчид болон 2, 3 дугаар курсын оюутан суралцагчдыг гэнэтийн ослын даатгалд бүрэн хамруулсан байна. | | |
| 1.6.8 | Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх | Ажил үйлчилгээний тоо: 4<br><br>Биелэлтийн хувь: 100<br><br>Эмзэг ба эрсдэлт нөхцөлд байгаа суралцагчдын талаар мэдээллийн санг бүрдүүлэх, төлөвөлгөө боловсруулах. | Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор судалгаа авч аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хүргүүлэн эрсдэлийн бүлгийг тогтоолгож, нийт 12 хүүхдийн судалгааг баталгаажуулан өрхийн нөхцөл байдалтай танилцсан тэмдэглэгээ хийсэн. 2023-2024 оны хичээлийн жилд эрсдэлт нөхцөлд байгаа суралцагчдад төлөвлөгөө гарган ажилласан.<br>Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 2 суралцагчын гэрээр орж эцэг эх асран хамгаалагчидтай | Эрсдэлт нөхцөлд байгаа суралцагчдын талаар мэдээллийн санг бүрдүүлэн хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна. | Хагас жилийн байдлаар сургуулийн хэмжээнд эрсдэлд нөхцөлд амьдарч байгаа 18 хүүхдийн судалгааг гарган гэрээр айчлах тэмдэглэл хөтлөн холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн.<br><br>Эрсдэлт нөхцөлд байгаа суралцагчдыг илрүүлэх зөвлөмжийн дагуу дахин 1 дүгээр курсийн 86 суралцагчийг хамруулж үүнээс 2 суралцагч дээр кейс үүсгэн Сумын Хамтарсан багаар үйлчилгээ үзүүлсэн. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | уулзаж, ярилцлагын тэмдэглэл хөтөлсөн. | | | |
| 1.6.9 | Оюутан суралцагчийн хөгжил, олон нийтийн ажилд сайн дураар оролцох, зохион байгуулах дадал хэвшлийг төлөвшүүлэх | Хийгдэх ажлын тоо: 4<br><br>Биелэлтийн хувь: 100<br><br>Хичээлээс гадуурх ажлаар суралцагчийг хөгжүүлэх, оролцоог дэмжиж үйл ажиллагаа зохион байгуулах. | Оролцооны клубийн суралцагч нар сайн дурын 3 чиглэлийн үйл ажиллгаанд нийт 73 оюутан суралцагч хамрагдсан. “Тэгш оролцоо-Хязгааргүй боломж” чуулга уулзалтанд 5 оюутан оролцож, аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүнээр оюутан Б.Отгонтуяа сонгогдон ажиллаж байна. | Суралцагчийн төлөвшил, нийгэмших үйл явц, олон нийтийн ажилд оролцоход мэргэжлийн багш нартай хамтран ажиллана. | 2024-2025 он хичээлийн жилд суралцагчдын дунд хичээлээс гадуур зохион байгуулах сургалт, соёл хүмүүжлийн ажлын нэгдсэн төлөвлөгөө, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх 15 ажил үйлчилгээтэй төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Оюутны өөрөө удирдах байгууллага, 12 клуб, дугуйланд нийт 210 оюутан, суралцагч хамрагдаж байна. | 100 |
| 1.6.10 | Оюутан суралцагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах | Үзлэгийн тоо: 3<br>Үзлэгт хамрагдах оюутны тоо: 450<br>Үзлэгийн биелэлтийн хувь: 100%<br>Суралцагчдын эрүүл мэндийн байдлыг оношилж, халдварт болон халдварт бус өвчнийг илрүүлэх ажлыг зохион байгуулна. | 404 суралцагч томуу, томуу төст өвчин болон бусад халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ, АШУҮИС-ийн НЭМС-ийн архи, тамхи, мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн хэрэглээ, нойргүйдэл, стресс, | Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулан Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллана. | Урьдчилан сэргийлэх үзлэгийн төлөвлөгөө боловсруулан үзлэг оношлогоог 2024 оны 09 дүгээр сарын 23-наас 27-ны хоорснд хийсэн.<br>Үзлэгт нийт 15 ангийн 156 оюутан суралцагч хамрагдсан ба эрхтэн тогтолцооны өвчлөлөөр авч үзэхэд Үүнд:<br>1. Шүдний гажиг-9 буюу 5.7%,<br>2. Шүдний өвчлөл-57 буюу 36.5%,<br>3. Хоол боловсруулах замын өвчлөл-14 буюу 8.9%,<br>4. Чих хамар хоолойг өвчлөл-33 буюу 21.1%,<br>5. Мэдрэлийн тоготолцооны | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | амиа хорлох эмгэг эрсдлийг илрүүлэх эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан. | | өвчлөл-7 буюу 4.5%,<br>6. Сэтгэцийн өвчлөл-1 буюу 0.6%,<br>7. Мэс засал-2 буюу 1.3%,<br>8. Гэмтэл 2 буюу 1.3%,<br>9.Бөөр шээсний замын өвчлөл-25 буюу 16%,<br>10. ДШБ-1 буюу 0.6%,<br>11.Нүдний өвчлөл-2 буюу 1.3% тус тус байна. Суралцагч нарт мэргэжлийн эмч нарын зөвлөгөөг өгч дараагийн шатний эмнэлэгийн байгууллагуудад хандаж оношлуулалх зөвлөгөө зөвлөмж өгсөн. | |
